



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 16 өдөр

Дугаар А/57

Мөрөн сум

Төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны
жагсаалт, төсөвт өртөг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.3, 41.2.6, 65 дугаар зүйлийн 65.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, Засгийн газрын 2021 оны 359 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Багийн хөгжлийг дэмжих төлөвлөгөө 3”-ийн хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Багийн Засаг дарга, багийн эмч нарт шаардлагатай теник хэрэгсэл, тоног төхөөрөмж” худалдан авах ажлын жагсаалт, төсөвт өртгийг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газар (Б.Должинсоргодог)-т даалгасугай.

3. “Багийн Засаг дарга, багийн эмч нарт шаардлагатай теник хэрэгсэл, тоног төхөөрөмж” худалдан авах ажлыг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны 08 дугаар
сарын 06 өдрийн А/ 57 дугаар
захирамжийн хавсралт

**“БАГИЙН ЗАСАГ ДАРГА, БАГИЙН ЭМЧ НАРТ ШААРДЛАГАТАЙ
ТЕХНИК ХЭРЭГСЭЛ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ” НИЙЛҮҮЛЭХ АЖЛЫН
ХҮРЭЭНД УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
АЖЛЫН ЖАГСААЛТ**

№	Үйл ажиллагаа	Тоо ширхэг	Шаардагдах хөрөнгө /сая. Төг/
1	Багийн Засаг дарга, багийн эмчийг унаажуулах	20	70,000,000
2	Багийн Засаг дарга нарт суурин компьютер худалдан авах	32	99,200,000
3	Хөдөөгийн 98 багийн эмчид зөөврийн компьютер худалдан авах	98	294,000,000
4	Багийн Засаг дарга нарт 3 үйлдэлт хэвлэгч	10	6,800,000
5	Улаан-Уул сумын Мунгараг багт бэлчээрийн худаг гаргах	1	30,000,000
Нийт дүн			500,000,000

___оОо___